МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн

МОНГОЛ УЛСЫН
“ЧИНГИС ХААН”
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн

МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

VI

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан

Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2023 оны 4 сарын 19-21
Монгол Улс, Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Улаанбаатар – Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Хариуцлагатай редактор: Академич С. Чулуун
Эмхтгэгч-редакторууд: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор И. В. Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D), проф Н. Хишигт
Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн Д. А. Носов

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга-VI. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2023 оны 4 сарын 19-21. Монгол Улс, Улаанбаатар хот. Улаанбаатар – Санкт - Петербург, 2025. – 320 тал.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, “Чингис хаан” Үндэсний музей, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн хамтран 2023 оны 4 дүгээр сарын 19-21-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, улс төр, хэл, утга зохиол, шашин соёл, угсаатны зүйд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2025
© Монгол Улсын “Чингис хаан” Үндэсний музей, 2025
© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2025

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

“ЧИНГИС ХАН”
Национальный музей
Монголии

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей

КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

VI

Международная конференция
при поддержке Президента Монголии

19-21 апреля 2023 г.
Монголия. Улан-Батор

Сборник докладов

Улан-Батор — Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И. В. Кульганек
доктор (Ph.D), проф. Н. Хишигт
кандидат филол. наук Д. А. Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов VI Международной научной конференции. 19-21 апреля 2023. Улан-Батор, Монголия. УБ. — СПб., 2025. — 320 с.

Сборник представляет собой собрание докладов VI Международной научной конференции “Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организованной Институтом истории и этнологии МАН, Национальным музеем Монголии Чингис-хан и Институтом восточных рукописей РАН в Улан-Баторе 19-21 апреля 2023 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, политике, языку, литературе, культуре, религии и этнографии монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Институт истории и этнологии МАН, 2025
© "Чингис-хан" Национальный музей Монголии, 2025
© Институт восточных рукописей РАН, 2025

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology

CHINGGIS KHAAN
NATIONAL MUSEUM
OF MONGOLIA

RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts

CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

VI

International Conference
Under the Patronage of the President of Mongolia

April 19-21, 2023.
Mongolia, Ulaanbaatar

Proceedings

Ulaanbaatar – St. Petersburg
2025

ННА 63
ДАА 900
М-694

Edited and compiled by Academician S. Chuluun
D.Sc.(Philology) I. V. Kulganek
Ph.D (History), prof N. Khishigt
Cand. Sc. (Philology) D.A. Nosov

Cultural heritage of the Mongolis: Manuscripts and archival collections-VI. Papers of the VI International Conference, April 19-21, 2023. Ulaanbaatar. Ulaanbaatar-St.Petersburg 2025, 320 pages.

This is a collection of papers, presented at the Sixth International Conference organized by the Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences, National Museum of Mongolia "Chinggis Khaan" and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in Ulaanbaatar in April 19-21, 2023.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-533-04-5
10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Institute of History and Ethnology MAS, 2025
© National Museum of Mongolia "Ghinggis Khaan", 2025
© Institute of Oriental Manuscripts RAS, 2025

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ

ӨМНӨХ ҮГ 10

МЭНДЧИЛГЭЭ /ПРИВЕТСТВИЯ..... 11

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсдод ирүүлсэн илгээлт..... 12

Приветственная речь Генерального секретаря Международной ассоциации монголоведения, директора Национального музея Монголии Чингис-хан, академика С. Чулууна 14

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И. Ф. Поповой 16

Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, (Sc.D) Ц. Цэрэндоржийн мэндчилгээ..... 18

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх
Нур ад-Дины гар бичмэл дундад зууны монгол хүний нэрийн сурвалж болох нь 22

Г. Баярмаа
Берлиний Улсын номын санд хадгалагдах Монголын бурханы шашинд холбогдох баримтын тухай..... 28

Т. Баясгалан
Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол тууль 43

Л. Ганбат
“Zafarnama” Монголын түүхэнд холбогдох сурвалж болох нь..... 52

Д. Дашдулам
1932 оны зэвсэгт бослогын нэгэн удирдагч Самбуу дүвчингийн тугийн талаар нэхэн үзэх нь 58

Ц. Дэлгэрсайхан
Монгол Улсын боловсролд Оросын сургагч багш, мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг архивын баримтаар тодотгох нь (1912-1942 он)..... 76

Zsolt Szilágyi
The Hungarian press perceptions of Mongolia at the beginning of the 20th century..... 89

И. М. Захарова
Караван купца Ивана Саватеева в Китай в 1702-1704 гг.
(По материалам Государственного Эрмитажа)..... 99

И. В. Кульганек
«Речь о состоянии монгольской словесности» из собрания
Института восточных рукописей РАН 108

Лицю Лю, Р. М. Валеев, Р. З. Валеева, Ю. И. Елихина, Д. Е. Мартынов
Формирование монголоведения, буддологии и тибетологии
в Казани в XIX в.: архивные фонды и материалы государственного
архива Республики Татарстан и музеев Казани 120

М. В. Мандрик
Коллекция документов по истории Русской духовной миссии
в Пекине и Монголии в собрании Научного архива ИИМК РАН 140

Д. Наранцэцэг
Хорчинба Ишжамцын намтар “Сүсэг төгөлдөр нугуудын зүрхний
энэлгийг арилгагч” хэмээх зохиолын шинжлэл 149

Б. Нацагдорж
Монгол Гэсэрийн туужийн үйсэн дээр бичсэн нэгэн эхийн тухай 162

Д. А. Носов
Загадка тетрадей Лисовского: о составе единицы хранения
« В.И. Лисовскийн тэмдэглэлийн дэвтэрүүд» из Центрального
Национального Архива Монголии 178

G.Odbayar
A Contribution to the study of Mongol bannermen: The founding policy
of the Tibetan Qing Administration, written by Sungyun 184

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
Монгол Улс дахь нутгийн аялгуу судлалыг архивын баримтаас
тодруулах нь 197

Т. Сайнжаргал
Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэх Түшээт засаг
гүн Балдардоржийн захидлын мэдээг мөшгөх нь 213

М. В. Федорова
Вклад Я. П. Шишмарева в формирование монгольского собрания
Российского этнографического музея 221

Н. Хатанбаатар
"Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивой" хэмээх сурвалжийн тухай 235

Н. Хишигт
О. И. Макстенек: Монголын тухай илтгэл, мэдээллүүд (1920-1921 он) 241

С. Цолмон, Ц. Энхчимэг
Еще раз о Золотоордынских тамгах Крыма 250

Ц. Цэрэндорж
Солонгосын Чосөнъ улсын үед монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичгүүдийн нэрийг тодруулах нь 262

S. Chuluun, Agata Bareja-Starzyńska
On the documents of the first population and statistical census of Mongolia in the 20th century kept in the archive of prof. W.Kotwicz in Cracow, Poland 274

Ц. Энхжаргал
Таван жилийн төлөвлөгөөг сайжруулах асуудалд холбогдох баримтын тойм (Монгол Улсын Үндэсний Төв Архивын материалаар) 291

ИЛТГЭГЧДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 310

DOI 10.48612/IVRRAN/6vv5-x9he-g73m *Д. Наранцэцэг (Монгол Улс)*

ХОРЧИНБА ИШЖАМЦЫН НАМТАР “СҮСЭГ ТӨГӨЛДӨР НУГУУДЫН ЗҮРХНИЙ ЭНЭЛГИЙГ АРИЛГАГЧ” ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН ШИНЖЛЭЛ

Товч агуулга: Арван долдугаар зууны үеэс Монголын олон номын мэргэд төвөд монгол хэлд тэгш боловсорч, зохиол бүтээлээ төвөд хэлээр туурвин бичиж болжээ. Хорчин нутагт гэхэд Ар хорчин хошууны ширээт лам жанагба Жамьяндамбийням, Гүнбум хийдийн Тэжээхүй ухааны дацангийн 51-р ширээт Ар хорчингийн шавран Жамьяндамбийжанцан**,** Ар хорчинба Ишжамц, түүний намтрыг туурвисан лам Принлайжамц тэргүүтэй төвөд хэлээр зохиол бүтээлээ бичдэг олон лам эрдэмтэн нэр гарсан билээ.

Бид энэ удаагийн өгүүлэлд төвөд хэлээр 2 боть зохиол бичсэн Хорчинба Ишжамцын (1860-1921) намтар “Зуун гол ёсыг өгүүлэгчийн эрхэт, ханьцашгүй зарлигийн ачит богд лам Ишжамц сайн цогтын түүх намтар сүсэг төгөлдөрийн энэлгээг арилгагч хэмээх оршвой” зохиолын агуулгыг төвөд намтраас нь орчуулан танилцуулж, судалгааны эргэлтэд оруулахыг зорьлоо.

Түлхүүр үг: монголчуудын төвөд хэлт утга зохиол, хорчинба Ишжамц, намтар зохиол

Narantsetseg D

ABOUT THE BIOGRAPHY OF KHORCHINBA ISHJAMTS, “THE REMOVER THE SUFFERINGS OF THE HEARTS OF DEVOTED PEOPLE”

It can be said that the work of recording and studying on Tibetan literature written by Mongolians, began in the latter half of the last century. Samaagiin Gombojav, the khamba lama of Gandantegchenlin Monastery, presented a paper entitled “Tibetan literature composed by Mongolians” at the First Conference of Scholars for Mongolian Studies held in 1959. This presentation presented an overview of the Tibetan writings works written by over 208 Mongolian lamas. In the article of S.Gombojav, only one monk from the Khorchin region is mentioned by name.

In addition, it is known that there were many lama scholars in the Khorchin region who wrote their works in Tibetan, including Janagpa Jamyandambinyam, the khamba lama of Ar Khorchin region, shavrun Jamyandambijantsan, the 51st khamba lama of the Medical College of Gunbum Monastery, Ar Khorchin Ishjamts, monk of Ar Khorchin Monastery, lama Prinlaijamts who wrote biography of Ishjamts.

We have also other records that the leraned lamas such as Tseden Lharamba of Uzemchin region, Doyodtsultim, the 6th khamba lama of Kalachakra College of Lavran Monastery, Agvanpuntsag, the 7th khamba lama of Kalachakra College of Lavran Monastery, and Luvsanlunrignyam, the 4th Deti incarnation, were invited as spiritual teacher in the Khorchin region, wrote their works, and preached their teachings in this region.

In this article, we aim to present the content of the biography of Khorchinba Ishjamts (1860-1921), who has two-volume work written in Tibetan, "The Biography of Great Lama Ishjamts, The Story of the Greatest Lama, Reciter of the hundred-fold dharma, Teacher of incomparable teachings" and to introduce this work into research field.

Keywords: *Tibetan literature of Mongolians, KhorchinbaIshjamts, biographical literature*

Хорчины номын мэргэдийн тухай товч өгүүлэх нь:

Монгол хүний төвөд хэлээр туурвисан зохиол бүтээлийг бүртгэн судлах ажил өнгөрсөн зууны сүүл хагасаас эхэлсэн гэж хэлж болно. Шанжийн Иштавхай ламын 1958 онд хийсэн лам нарын бүтээлийн бүртгэлд суурилж, Гандантэгчэнлин хийдийн хамба лам, хамба номун хаан Самаагийн Гомбожав абугай 1959 онд хуралдсан Монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд "Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл" илтгэлийг хэлэлцүүлсэн ба тус илтгэлд 208 монгол ламын төвөдөөр бичсэн зохиол бүтээлийн тоймыг үзүүлж, "үүнд дурдсан нь хэрхэвч бүрэн бус бөгөөд цааш нь бас ном зохиолыг нь үзэж нэмэн тодорхойлох нэр олон гарах нь лавтай" [Гомбожав 2005: 10] хэмээсэн байдаг.

С. Гомбожав хамбын өгүүлэлд "Жамьяндамбийням. Ар хорчины хошууны ширээт. 19-р зууны хүн, зохиол нь 2 боть, судар тарнийн тайлбар. Бээжин бар" [Гомбожав 1959: 16] хэмээн Хорчин нутгаас гарсан ганц ламын тухай мэдээлжээ.

Энэхүү Жамьяндамбийнямыг зарим эх сурвалжид 1686 онд төрж, 1738 онд таалал төгссөн хэмээдэг. Түүний сүнбумын эхний ботид 12

зохиол, 2-р ботид 21 зохиолыг багтааж Лавран Дашчил хийдэд барласан гэжээ. Төвөд хэлээр бичсэн ном судраас түүний үйлс бүтээлийг мөшгөн үзвэл тэрбээр нийт 3 боть сүнбумтай, дэлгэрэнгүй намтар үгүй бололтой байна [Сүнбум гарчиг 1990: 313-315].

"Богд Жамьяндамбийнямын намтар, зарлиг зохиолын хураангуй" нэртэй өөрийн намтрынхаа төгсөлийн үгэнд:

"*Ном ч биш, үлгэр ч биш үгсийн эрих үүнийг*
Сүсэгтэй биш, хүсэлтэй биш, шунал мунхрахын эрхээр
Хятад ч, төвөд ч биш ч, хятад нэрт бээр
Ламын ч биш, харын ч биш, хуушааны хийдэд бичив" гэж бичсэн байдаг нь сонирхолтой.

Энэ нь Жамьяндамбийням ламтан амьдралынхаа сүүлийн жилүүдэд Хятадын Утай ууланд[1] заларч бясалгал бүтээлд шамдаж байсны дээр жанагба Агваанпунцагийн хувилгаан учраас жанагба хэмээх өргөмжлөх болсныгоо *хятад ч биш, төвөд ч биш, хятад нэрт* хэмээн бичсэн бололтой.

С. Гомбожав хамбын өгүүлэлд нэр цохон дурдагдсан Ар хорчин хошууны ширээт лам, жанагба Жамьяндамбийнямаас гадна Гүнбум хийдийн Тэжээхүй ухааны дацангийн 51-р ширээт Ар хорчингийн шавран Жамьяндамбийжанцан[2], Ар хорчинба Ишжамц, түүний намтрыг туурвисан лам Принлайжамц[3] тэргүүтэй төвөд хэлээр зохиол бүтээлээ бичдэг, Хорчин нутгийн олон лам эрдэмтэн байсан нь мэдэгдээд байна.

Түүнчлэн Үзэмчиний Цэдэн лхарамба[4], Лавран хийдийн Дүйнхор дацангийн 6-р ширээт Доёдцүлтим[5], Лавран хийдийн Дүйнхор

---

1 Chinese: 五台山 Одоогийн БНХАУ-ын Шань си мужид орших Хятадын буддын шашны 4 их хийдийн нэг. Монголчууд Таван шанхат уул, Сэрүүн тунгалаг уул гэх зэргээр бичиг сурвалжид тэмдэглэж иржээ.

2 Жамьяндамбийжанцан нь Гүнбум хийдэд заларч, Балданшаддүвлин дацангийн чойрт орж, хоёр жил илүү бололгүй дацангийн ширээнд томилогдсон байна. Шинса Доржчэнгийн өмнөөс гэлэн сахил хүртэж, 15-р жарны шарагчин туулай жил ширээнд залагджээ. Хоёр ёсны үүднээс дацангийн үйлийг сайтар тэтгэсний эцэст өөрийн нутагтаа заларчээ [Гүнбум данрав 1982: 331].

3 Принлайжамц. 20-р зууны үеийн хүн. Ишжамцын намтрыг зохиосон

4 Хорчин ноён хутагт гэгээний багш байсан.1847 онд Хорчин Хутагтын хийдэд залагдан очиж, Жирмийн чуулганы Хорчин ноён хутагт ламын хийд буюу Засагт хошууны Туулайт гэгээн сүмд Лувсантүвдэнжигмэджанцан гэгээний ёнзин багш болсон ба түүнд сахил хүртээж, тэнд хоёр жил суужээ. Хожим нь дахин Ноён хутагт ламын хийдэд залагдан суусан гэж "Хорчин ноён хутагт гэгээний намтар"-т тэмдэглэжээ. Төвөд хэлээр бичсэн 2 боть сүнбум зохиолтой. Монгол хэлээр доктор Г. Мягмарсүрэн орчуулан, Мангала питака цувралаар хэвлүүлжээ.

5 1727 онд төрсөн, Ар хорчинд залагдсан.

дацангийн 7-р ширээт Агванпунцаг[6], Дэти хувилгааны 4-р дүр Лувсанлүнригням[7] нарын лам эрдэмтэд Хорчин нутгийн ламаар залагдан сууж, тэр нутагт зохиол бүтээлээ туурвиж, сургаал номлолоо хайрлаж явсан мэдээ бий.

Эдгээрээс Хорчинба Ишжамц лам нь 1860 онд төрж, 1921 онд нас баржээ. Түүнийг Ишжамц, Ар хорчинба Ишжамц, Хорчинба Ишжамц ч гэх зэргээр бичиж тэмдэглэж иржээ. Шавь нараас алдартай нь гэгээчүүлээс гэхэд Донхор хутагтын 11-р дүр Лувсанцүлтимжигмэджамц (1891-1909), Донхор хутагтын 12-р дүр Лувсантүвдэнлүнригшаддүвжамц (1910-1920) нар юм. Их хүрээний мэргэдийн эрхэт цорж Агванбалдан цоржийн хувилгаан энэ лам гүн ухааны эргэлзээтэй утгуудад утгын шинжлэл буюу догжод хийснээрээ алдартай.

Ишжамц хоёр боть[8] зохиол бичжээ.

Нэгдүгээр ботид:

1. Зуун гол ёсыг өгүүлэгчийн эрхэт, ханьцашгүй зарлигийн ачит богд лам Ишжамц сайн цогтын түүх намтар сүсэг төгөлдөрийн энэлгээг арилгагч (gzhung brgya smra ba’i dbang po bka’ drin mnyam med rje btsun ye shes rgya mtsho dpal bzang po’i rtogs brjod pa dad ldan snying gi gdung sel shes bya ba bzhugs so/)
2. Нотлох ухааны зарим нэгэн бэрх оньсыг шинжлэх ёс товчлон хураасан мэргэдийн сэтгэлийг булаагч (gtan tshigs rig pa’i dka’ gnad ‘ga’ zhig la dogs dpyod kyi tshul mdor bsdus pa mkhas pa’i yid ‘phrog ces bya ba bzhugs so/)
3. Бүтээлийн хэлний тайлбар эш ухааны эрдэнийн хүү сан (sgrub ngag gi rnam gshag lung rigs rin chen gter mdzod ces bya ba bzhugs so/)
4. Оюун ухааны нийтийн утга товчлон хураасан шинжлэл лүгээ сэлтийн тайлбар эш ухааны эрдэнийн хүү сан (blo rig gi spyi don mdor bsdus dogs dbyod dang bcas pa’i rnam gzhag lung rigs rin chen gter mdzod ces bya ba bzhugs so/)
5. Шалгадаг үрийн шинжлэл тодорхой оюутын хүзүүний чимэг эш ухааны эрдэнийн сан (tshad ‘bras kyi dogs dpyod blo gsal mgul rgyan lung rigs rin chen bang mdzad ces bya ba bzhugs so/)
6. Сэтгэл хийгээд сэтгэлээс гарахын тайлбар нийт утга шинжлэл

[6] 1746 онд төрсөн, Гончигжигмэдванбугийн зарлигаар Ар Хорчингийн Дагдан бэйлийн хошууны ламаар суусан.

[7] 1862 онд төрсөн, 1874 онд нас барсан. 1866 онд Аку Шэйравжамцаас сахил хүртээд, 1871 онд Утайд заларчээ. Тэндээсээ Баарин ван, Ар хорчин бэйл, Майдар хутагтын заллагаар нутаг оронд нь (Долоон булагт) заларч байжээ.

[8] rje btsun hor chen pa ye shes rgya mtsho’i dogs dpyod phyogs bsdus bzhugs so//

лүгээ сэлт эндүүрлээс хагацсан амьтны мунхагийн харанхуйг арилгагч (sems dang sems byang gi rnam gzhag spyi don dogs dpyod dang bcas pa ‘khrul bral ‘gro’ba’i mun sel zhes bya ba bzhugs so//)

7. Тогтсон тааллын шинжлэл тодорхой оюутын хүзүүний чимэг эш ухааны эрдэнийн хүү сан (grub mtha’i dogs dpyod blo gsal mgul rgyan lung rigs rin chen gter mdzod ces bya ba bzhugs so//)
8. Газар мөрийн хязгаарын шинжлэл лүгээ сэлтийн тайлбар төгс шинжлэлтнийг баясгагч (sa lam gyi khyab mtha’ dogs dpyod dang bcas pa’i rnam bzhag dpyod ldan dga’ byed ces bya ba bzhugs so//)
9. Бодит 8 хийгээд 70 утгатын хязгаарын тайлбар ухааны мөр өдөр үйлдэгч эрхтийн гэгээ (dngos po brgyad dang don bdun cu’i khyab mtha’i rnam gzhag rig lam nyin byed dbang po’i snang ba zhes bya ba bzhugs so/)
10. Цадиг гурван үүдний нийт утга шинжлэл лүгээ сэлтийн тайлбар ахуй ёсыг тодотгогч (rnam thar sgo gsum gyi spyi don dogs dpyod dang bcas pa’i rnam gzhag gnas lugs gsal byed ces bya ba bzhugs so/)

Хоёрдугаар ботид:

1. Бодитой 8 хийгээд 70 утгатын шинжлэл эш ухааны зул (dngos po brgyad dang don bdun cu’i dogs dpyod lung rigs sgron me zhes bya ba bzhugs so/)
2. Асуусны хариу цагаан лянхуан эрхисийн шинжлэл рашааны гэрэлт (dris lan pad dkar phreng ba’i dogs dpyod bdud rtsi’i ‘od can zhes bya ba bzhugs so/)
3. Шударга магадыг тийн ялгагчийн шинжлэл сайн номлол бүхэн хурсан (drang nges rnam ‘byed kyi dogs dpyod legs bshad kun btus zhes bya ba bzhugs so/)
4. Авидармын сангаас гарсан нэрийн зүйл хийгээд тэдгээрийн олох ёс тэргүүтнийг тодотгон үйлдэгч ухааны мөр чандманийн сан (chos mngon mdzod nas byung ba’i ming gi rnam grang dang de dag gi rnyed tshul sogs gsal bar byed pa’i rigs lam nor bu’i bang mdzod ces bya ba bzhugs so/) зэрэг номууд оржээ.

Хорчинба Ишжамцын намтар зохиолыг шинжлэх нь: Бидний өгүүлэн буй намтар нь түүний бүрэн зохиолын нэгдүгээр ботид буй. Намтрын бүтэн нэр нь: “Зуун гол ёсыг өгүүлэгчийн эрхэт, ханьцашгүй зарлигийн ачит богд лам Ишжамц сайн цогтын түүх намтар сүсэг төгөлдөрийн зүрхний энэлгээг арилгагч хэмээх оршвой”[9].

---

[9] ཨཱཿ།གཞུང་བཟང་སྨན་བའི་དབང་པོ་བཀའ་དྲིན་མཁྱན་མེད་རྒྱ་བཙན་ཡེ་ཤེས་རྒྱ་མཚོ་དཔལ་བཟང་པོའི་རྟོགས་པ་བརྗོད་པ་དང་ལྡན་སྟེང་གི་གཏེར་སྒོ་བ་བཞུགས་སོ།།

Зохиолын бүтэц нь тахил өгүүллээс гадна 7 бүлэгтэй. Дэвтэрлэсэн номоороо 28 хуудас. Бүлэг бүрийн нэр нь:

1-р бүлэг: Хотол чуулсан язгуур угсаанд лагшин мэндэлсэн (tib: རིགས་ཅས་ཕུན་ལྡན་ཚོགས་པར་སྐྱེ་བཞུགས་སྐྱེ་དང་པོའོ།།)

2-р бүлэг: Гэрээс машид гарч үсэг бичгийн язгуурт суралцсан (tib:རབ་ཏུ་བྱུང་ཞིང་ཡིག་རིགས་བསླབ་པའི་སྐྱེ་གཤིས་པའོ།།)

3-р бүлэг: Гэнэн сахил хүртэж, аяга тахимлэгийн ухааныг өгүүлэхийн эрх баялаг болсон (tib:བསྟེན་པར་རྫོགས་ཤིང་རིགས་སྐྱ་བའི་དབང་ཕྱུག་ཏུ་གྱུར་པའི་སྐྱེ་གསུམ་པའོ།།)

4-р бүлэг: Номын их хийд Гүнбумжамбалин хийдэд заларч равжамбын цол мяндаг хүртэж, сонсох судлахыг ямар мэт зохиосон (tib:ཆོས་སྡེ་ཆེན་པོ་སྐྱ་འབུམ་བྱམས་པ་གླིང་ཏ་ཕེབས་ནས་རབ་འབྱམས་པའི་མཚན་བཏགས་བཞེས་ཤིང་གསན་སྒྲོང་རྗེ་ལྟར་མཛད་པའི་སྐྱེ་བཞི་པའོ།།)

5-р бүлэг:Балминжүрдашчойдин хийдэд шашны үйл ямар мэт зохиосон (tib:དཔལ་མི་འགྱུར་བཀྲ་ཤིས་ཆོས་སྒྲིངས་སུ་བསྟན་པའི་བྱ་བ་རྗེ་ལྟར་མཛད་པའི་སྐྱེ་ལྔ་པའོ།།)

6-р бүлэг: Сүүлийн үйлс зохионгуйг ямар мэт үзүүлсэн (tib:མཛད་པའི་ཐ་མ་རྗེ་ལྟར་བསྟན་པའི་སྐྱེ་དྲུག་པའོ།།)

7-р бүлэг: Аман гэрээслэлийг сайтар бүтээсэн (tib:ཞལ་ཆེམས་ཀྱི་མཐའ་ལེགས་པར་གྲུབ་པའི་སྐྱེ་བདུན་པའོ།།)

Төгсгөлийн үг нь:

“ཅེས་བདག་ཅག་གི་དཔལ་ལྡན་བླ་མ་དམ་པ་རང་གཞན་གྱི་གྲྭབ་མཐའ་རྒྱ་མཚོ་ལྟ་བུའི་ཕ་རོལ་ཏུ་ཕོན་ཞིང་འཚང་རྒྱུད་རྒྱུམ་གསུམ་ལ་འཇིགས་པ་མེད་པའི་ཁུ་མཚོག་རླབས་པོ་ཆེའི་གནས་ཐོབ་པ་ཡོངས་ཀྱི་བཤེས་གཉེན་ཆེན་པོ་ཇི་བཞིན་ཡེ་ཤེས་རྒྱ་མཚོ་དཔལ་བཟང་པོའི་རྟོགས་པ་བརྩོད་པ་དང་ལྡན་སྲིང་གི་གཏང་སེལ་ཞེས་བྱ་བ་འདི་ནི།གཞན་བསྟན་པའི་དབང་པོ་བན་ཐོ་ཕྱབ་བསྟན་རིག་གོལ་ཁྱེ་མས་རྒྱ་མཚོ།ཤེས་བཞིན་དགེ་འདུན་བསྟན་རྒྱས་ཐམས་རྒྱ་མཚོ་ཤེས་ཀྱི་ཁ་ལོ་ཅན་ཁ་ལ་ཞིང་ཁ་ཆར་བསྲེལ་ཞིང་།རང་ཉིད་ཀྱང་ཆོ་རབས་ཀྱི་ཕྱེང་བར་རྟེས་སུ་འཇོན་པའི་རྟེན་འབྲེལ་བསྲིག་ཕྱིར།ཁྱེད་ཀྱི་བཀའི་ཡང་བན་བཙུན་གཟུགས་འཕྲིན་ལས་རྒྱ་མཚོའམ།ཞིང་གཞན་ཚར་གྱས་བཞད་པའི་བློ་གོས་ཀྱིས།ཁྱེད་པར་ཕོ་བྱི་བའི་ལོར།དཔལ་མི་འགྱུར་བློ་ཟངས་ཀྱི་ཤིས་ཆོས་སྒྲིངས་ཀྱི་རང་ཤག་ཡོན་ཏན་འཕེལ་རྒྱས་ཀྱིང་ཏ་སྒྲུར་བ་དགེ་ལེགས་འཕེལ།།ཇི [[Принлайжамц 2001:28]: *Бидний дээд багш цог төгөлдөр дээд багш, өөр бусдын далай мэт тогтсон тааллын чанадад хүрсэн бөгөөд номлох, тэмцэх, туурвих гуравт эмээх үгүй сүргийн манлайн дээд орныг олсон огоот олны их буяны садан богд тойн Ишжамц сайн цогтын намтар сүсэг төгөлдрийн зүрхний энэлгээг арилгагч хэмээх үүнийг зуун гол ёсыг (шастир) өгүүлэгчийн эрхэт Түвданрэгдол, Жадо Цүлтимжамц, Шэйшин*

Гэндэнданжай тэргүүтэн итгэл түүний бодитой дотоод шавь зарим нэгнээс ихэд шамдан дуртгасан хийгээд би өөрөө ч гэсэн төрөл тутам бүхэндээ багшийг даган барихын шүтэн барилдлага жигдлэхийн тулд дээдэс түүний зарлигийн зардас тойн дүрст Принлайжамц, бус нэр нь Цансрай Шадвийлодой (Эсрүагийн хөвгүүний мөшөөх оюун) хэмээгч мягмар хэмээх хөх хулгана жил Бал минжүрдиза дашчойдин Цогт үл урвах өлзий хутагийн номын оргил буюу Диза хийдийн Ёндонпэлжайлин гэдэг өөрийн лаврандаа найруулав. Буян арвижих болтугай” гэжээ.

Төгсгөлийн үгнээс сүвэгчлэн хөөж үзвэл тус намтрыг Принлайжамц гэгч, мягмар хэмээх хөх хулгана жил буюу 1924 онд зохиосон байна. Принлайжамцын бус нэр нь Цансрай Шадвийлодой ажээ. Хорчинба Ишжамцын шавь бөгөөд 20-р зууны үед амьдарч байжээ. Тэрээр Балминжүрдизадашчойдин буюу Диза хийдийн Ёндонпэлжайлин гэдэг өөрийн лаврандаа энэ намтрыг бичсэн гэдэг нь тодорхой байна. Диза хийд нь Хөх нуурын өмнө талд байдаг, одоогийн Шин хай шяньд харьяалагддаг газар орон юм. Диза хийдийг мөн Ганданшаддүвдаржайлин хийд гэж бичиж тэмдэглэсэн нь таарч байв.

Зохиогч зохист аялгуу, яруу найрагт маш сайн нэвтэрсэн учраас тахилын шүлэг, завсрын шүлгээр уран яруу чимэглэн бичсэн нь нэн яруу. Эхлэл, төгсгөлийн шүлгүүддээ Хорчин Ишжамц багшийнхаа алдар, багшийнхаа багш Гэндүнданзинжамцын алдрыг оруулж бичжээ. Тухайлбал:

ཨཱཿ།།ལྷན་སྐྱེས་ཡེ་ཤེས་བདེ་བ་ཆེན་པོ་ལས།།གཡོ་བ་མེད་བཞིན་སྣུ་མའི་རོལ་གར་འཐུམ།།བསྡུར་མལས་རྒྱལ་བ་རྒྱ་མཚོའི་ངོ་བོ་ཉིད།།དཔལ་ལྡན་བླ་མ་སྲིད་ཞིའི་གཙུག་ན་རྒྱལ།།ཕྱུན་ཚོགས་ཀྱི་གཞི་རྡེན་བླ་ན་མེད།།ཟག་མེད་ཡེ་ཤེས་མཚོག་གི་མཐར་སོན་ཏེ།།སྨལ་བཟང་རྒྱ་མཚོའི་རे་བ་ཡོངས་སྨོང་བའི།།སྐྱབས་མཚོག་ཤྲཱི་སེངྒེས་དགེ་ལེགས་སྟོལ།།ཟུ་མེད་རྒྱལ་བ་ཀུན་གྱི་ཡེ་ཤེས་ལས།།ལེགས་གྲུབ་དམར་ཞེར་འོད་དུ་འབར་བའི་ལྷ།།འགྲོ་ཁམས་རྒྱ་མཚོའི་ནང་གི་ཟུན་ལེགས་ཏེ་ཤ་ལ་ཁ་ཅིག་ཏུ་ཡང་ཁ་ཅིག་ཏུ་ཡང་ལ་ལ་ཡོངས་ཀུ་ཕ་ཅོ་ཆེ་ཡ་ལ་ཡ་ཡ་ཡ།།ཟུ་ཁ་ཅིག་ཏུ་ཡ་ལ་ཡ་ཡ་ཡ།།ཟ

བར་སྒེལ་ནུས་ན།།ཐར་འདོད་རྒྱུ་པོའི་ཚོགས་ལ་ཕན་ཞེས་གྱགས།།གཞན་ཡང་དུས་གསུམ་རྒྱལ་བའི་ཡོན་ཏན་ལས།།རང་གི་བློ་མའི་ཡོན་ཏན་གཅིག་བརྗོད་པ།།ཕན་ཡོན་ཆེ་བར་མདོ་རྒྱུད་དུ་མ་ལས།།མཐུན་པར་གསུངས་ཕྱིར་བདག་བློ་ཅིས་མི་རང་ངས།།འཕོར་བའི་ཐུག་ཀུན་ནད་བརྒྱ་ཞེལ་བའི་སྨན།།མངོན་མཐོ་ངེས་ལེགས་ལམ་བཟང་ལྟ་བའི་མིག།ངམ་པའི་རྟོགས་བརྗོད་ལས་ལྷག་ཡོད་མིན་པས།།ཏི་ཚུལ་བརྗོད་ལ་བློ་ལྡན་སུ་ཞེག་ག�sདུང་།།ལྷར་སྨང་ཡོན་ཏན་བ་ཚའི་ཁྲོན་པ་ལ།།འོས་མིན་བསྟན་པའི་གཅམ་ཚོག་མང་སྒེལ་ཏེ།།རིགས་མཐུན་སྨང་བ་འཕྲིད་པའི་སྨྱོན་ཏམ་ཅན།།འགའ་ཞིག་མཚམ་ཀྱང་དེ་དང་འདི་མི་འདྲ།།མཁས་བཙུན་བཟང་པོའི་གཏིང་མཐའ་དཔག་མི་ཕོད།།འཆད་ཚོད་ཚོམ་པའི་ཁྱད་ནོར་ཡོངས་ཀྱང་ལྷན།།གཞན་ལས་ཆུབས་ཕྱེང་ཡོལ་མེད་པའི།།ཡོན་ཏན་ཡིད་བཞིན་འོ་མཚོ་གཏམ་གྱི་གཞི།།དེས་ན་ཐོན་སྨྱངས་ལས་ཀྱི་འཕྲོ་ས་ངེ།།ཚོས་ལ་མོས་ཤིང་བློ་གོས་ཡངས་པ་རྣམས།།ལེགས་བཤད་གསེར་བའི་ཟླ་བ་འདི་ལོངས་དང་།།དད་པའི་རྒྱ་མཚོ་འཕེལ་བ་དངོས་པོའི་གཤིས།། [Принлайжамц 2001:1] хэмээн тахилын шүлгийн 1-р бадагт Ишжамц гэж нэрийг шигтгэж оруулаад, Ишжамцын мөргөл, 2 дахь 8 шаданд багшийнхаа нэрийг дахиж оруулаад өлзий хутаг орших залбирлын 8 мөр бичээд, дараа нь Янжинлхам бурхны мөргөл, Хорчин Ишжамцын багш Гэндүнданзинжамцын ачийг санасан шүлэг, түүний дараагийн 5 шад нь намтар зохиох учир холбогдол, намтар зохиоход өөрийн хүчин мөхсөөс эрдэм чадлыг дутуу гаргасан, өөрийгөө доорд барьсан хэсэг гарч байна.

Намтрын эхний хэсгийг өөрөө насных нь сүүл үеэс шадарласан тул хожим нь багшийнхаа аман гэгээнээс яриулж авсан зүйлүүдээ найруулан бичсэн бол сүүл хэсгийг багшийнхаа хажууд шадарлан суух болсон цагаасаа өөрийн нүдээр харснаа бичсэн байдалтай. Намтрын эхлэл хэсэгт багшийнхаа урд төрлийн тухай асуухад: “Түүний урд төрөл нь Их хүрээний мэргэдийн эрхэт цорж Агванбалдан хэмээх яруу алдрын гагц цагаан шүхрээр хамаг газар дээрхийг түгээгч тэр ямагт мөн бөгөөд богд бусад орноо ажрахын урд жил өчүүхэн надад би Балдан цоржийн хувилгаан мөн хэмээн айлдсан” гэх буюу Мэндэлсэн газар болоод эцэг эхийн тухай хэсэгт: “Богд өөрийн аман гэгээнээс миний эцэг Дархан вангийн хошууны да тайж Ярпэл, ээж Сүнүжан, эцэг эх хоёрт 5 хүү байгаагийн би хамгийн отгон нь. 14-р жарны цагаан бич жил төрсөн. Миний багын нэр Ендонжамц” хэмээн айлдаж байв хэмээн бичжээ.

Мөн 2-р бүлгийн эхэнд төрх байдлыг нарийн өгүүлсэн хэсэгт, багын нэр нь Ёндонжамц гэж өгсөн тухайд түүний “Ирээдүйд гарах лугаа зохилдсон алдар Эрдмийн далай хэмээн нэрийдсэн ч эл богд судар тарнийн ухааны хамаг орон бүхнээ эрхшээж, эш хийгээд онолын эрдмийн дээдэд болсон хийгээд сайн хувьт оюун саруул огоот олноо өөр бусдын далай мэт тогтсон таллын номлол журам адил бус нарийнаас нарийн нугуудыг ч хольцол үгүйгээр мутрын алганы эд мэт тодорхой

болгоох их огоот баригч багшийн алдар үйл лугаа зохилдох энэ мэт гарахын урьдын бэлгэ мөн нь илт болой” хэмээн Эрдмийн далай буюу Ёндонжамц хэмээх нэрийг нь оруулан бичжээ.

9 настай байх үедээ да лам Ишданзингаас уншлагын зүйл заалгаж, гэнэн гэцэл сахил хүртээд, 9-15 нас хүртэл энэ багшийн дэргэд сууж ном үзсэн хэмээн айлдсан бөгөөд 2-р бүлгийн төгсгөлд энэ Ишданзан багшийнх нь нэрийг оруулж шүлэглэжээ.

Мөн зүүн Жаруудын Боржгон хийдэд шавилан суугаад, дараа нь ар Хорчингийн Дашгэмпэл хийдийн цанид чойрт хурах болжээ. Энд байхдаа цорж Цэрэндаш, да лам равжамба үзэмчин Лэгшад хоёрт шавь орж, цанид чойрын номыг сурч эхэлжээ.

20 нас сүүдэртэй байх үедээ хамба гэгээн Ишванчиг ламаас гэлэн сахил залаад Ишжамц буюу Билгийн далай нэр авсан. Үүнээс хойш намдал, зод зэрэг ном сурч цээжилж, шалгалт өгсөн. Дүнта зава (Тогтсон тааллын үндэс), дэлбэ донсэл (Утга тодорхой тайлбар) номуудыг цээжилснээ 2000 шахам удаа уншиж жорчэ хийжээ.

Мөн энэ үед Алшаа равжамба Санжайчойдаг ламаас Намдэл, Сэрпрэн, Намшиднянбожан зэрэг ном хүртсэн. Энэ үедээ мөн “тэр цаг үед Хан тайгүн сүм, Ар хорчины Ноён сүм, баруун жаруудын Ноён сүм гурав цанидын хичээл сургуулийн талаар хамгийн их хэмээн алдаршиж байсан. Ишжамцыг эдгээр хийдүүдэд Намдэл, Парчэн хоёрт Алшаа равжамбатай эн зэрэгцэнэ гэж яригддаг байв. Учир нь Парчэн домын үеэр Ламчойнзэдийг 3 өдөр тавих үед Сэнбрэй гүсүм (Сэра Брайвүн, Гандан) Гүнбүм, Бадгарчойлин хийдээс олон хувраг ирж, дагсал хаясан. Энэ үед Ишжамц би өөрийн чадлын хэрээр хариу талбихад олон лам нар “Энэ мэт дамжаа урд гараагүй, хойшид гарах ч ховор. Үүнээс илүү ном давтаж үзэж байгаа дацан сургууль ер үгүй гэж хэлэлцэхийг сонссон” гэж өөрөө айлдаж байв хэмээн бичжээ.

Түүний дараа Гүнбүмд үргэлжлүүлэн сурахаар очоод, Урад гэвш, Бари гэвш нарыг шүтэж ном сурсан хэмээсэн нь бүгд монгол хүмүүс бололтой. 40 насандаа Молом равжамбын дамжаа тавьсан, 41 наснаас гэвш ринбүчийн аглаг хийдэд сууж, төвөд, монгол хүмүүст номыг хөтлөх болсон гэж багш айлдаж байсан гэсэн байна.

Ишжамцын намтрыг зохиогч Принлайжамц энэ үеэс цанид чойрын ном судлах туслах нөхөр нь болж, бараадах болж, багшаасаа ум, зод, дүлбаг заалгасан байна. Энэ үеэс багшаасаа хийд хийдийн цанид чойрын ном хэлэлцэх ёсны ялгаа, журам хэрхэн явагдаж байсныг багшийнхаа аман гэгээнээс сонссоноо оруулсан байгаа нь сонирхолтой, үргэлжлүүлж судлууштай. Ер нь энэ үеэс хойш гарах хэсэг нь багшийнхаа хажууд

шадардан сууж, өөрийнх нь ярьсан болон өөрийн үзсэн харсныг бичсэн байдалтай.

Тухайлбал, Ишжамц ламыг ямар ямар багшаас ямар ямар номын ван лүн авшиг хүртсэнийг гаргахдаа тэр ном хүртээсэн багш нь ямар хүн болохыг бас тодорхой өгүүлсэн байна. “Чин сүзэгт номун ханы ёнзин Лувсанцэрэн ламаас Ажаа гэгээний сүмбүм, туган гэгээний Сүнбүмийн лүн, Дамдинчойгар гэх мэтийн номын лүн хүртсэн. Үүний дэлгэрэнгүйг Ишжамц ламын Сан-Иг дотор буйг үз” гэсэн буйгаас үзвэл түүний Сан-Иг гэж тусдаа зохиол гарсан ажээ.

Цааш үргэлжлүүлэн “Үзэмчин гэвш Лэгшадаас бас энэ үед Дүйра заалгасан. Чүнжа газрын Самданлин, Диза хийд, Гүмбүм болон бусад аглаг орон хийдэд Сэрпрэн, Намшад, Ламрим, Дүнтачэнбо, Агримчэнбо, Тогмарложон, Ондогжан гэх мэтийг заах, лүн хүртээх, хөтөлбөр тайлбар тавих гэх мэтийг олонтоо үйлдсэн. Энэ үед зарим шавь нь ихэд сүсэглэж, бахдаж байсан” хэмээгээд багшийн бэлгэ чанар бүрдсэн байсан тухайд нь бас намтарт өгүүлж байна.

52 насны цагаагчин гахай жил мэлмий нь тунгалаг бус болоход Намтарсолдэв дадангаажид буюу Сүсэг төгөлдрийг баясгагч гэдэг намтар залбирал зохиогоод Принлайжамцад “Чи үүний тайлбар аврал итгэл очирдарын дэлгэрэнгүй намтрыг бичээрэй” гэж зарлиг соёрхож байжээ. Үүнээс үзвэл Принлайжамц нь намтраар мэргэшсэн лам байх магадлалтай байна.

62 насныхаа цагаагчин тахиа жил Диза хийдэд дахин заларч, энэ хийдэд Хайлангийн хурал шинээр гаргажээ. Олон хоногоор ном айлдсан. Тэр мэт гүн дэлгэрэнгүй номын зарлигийг олон дахин хүртсэн бодитой шавь, Төвөдийн 3 том хийд, бусад хийдийн лам нар Ганга мөрний элсний тооноос олон гарсан хэмээн бичсэнээс үзэхэд тэр үед монголчууд аатай, алив орон хийдийн багш лам нь монгол лам нар байжээ.

Шашны үргэлжлэлд туслахын тулд зарлиг зохиол ямар мэт айлдсан шастирууд нь: Аврал итгэл Очирдара сангха алдартын намтар залбирал, Лориг Дагриг, Сэтгэл сэтгэлээс гарах, Газар мөр салам, Тогтсон таааллын шинжлэл, 70 утгатын шинжлэл, Зарим нэгэн асуусны хариу дилан, Асуусны хариу цагаан лянхуан эрхисийн хориг, Төв үзлийн шинжлэл, Зод зава Үндсэн авидармын сүвэгч тайлбар, Винайн үндэс, Винайн товчийн сүвэгч тайлбар, Тарнийн мөрийн зэргийн залгамж, Жанрайсигийн магтаалын тайлбар, Маанийн тус эрдэм, Үргэлжийн анхааран авлага, Дууны шастирын тайлбар, Дууны судар хоёр хэл хавсарсан зурхайн аймаг зарим нэгэн, Их төрөлхтөн зарим нэгний төрөл

үе даган барих залбирал, Өлмий батдах залбирал тэргүүтэн маш олон байх боловч зарим нэгэн залж авч яваад буцааж өгөөгүй тул эмхэтгэхэд барлаж оруулж чадаагүй гэж намтарт нь гарч байна. Энэ нь Хорчинба Ишжамцын сүнбумыг бидний судалгаандаа ашигласан Хонконгийн дэвтэрлэсэн номоос өмнө бар судраар гарч байсныг илтгэж байгаа юм.

Таллын анхааран авах уншлага бясалгал нь хумхан доторх зул мэт бусдад илтэд үл үзэгдэн зохиосон тул ямарчлан өгүүлэхүйеэ бэрх боловч бодитой үзэгдэх нь аглаг даяанчийн мутрын авлага мэт хэлний адислага, дүншаг, залбирал, дүйдан, балин өргөл тэргүүтнийг уншсаны дараа өглөөний цайгаа зооглодог, аль олноор мөргөл үйлддэг, өдрийн гүнцэгний үед шүтэн барилдлагын магтаал, идээний тахил, унал наманчлах сэлт уншдаг. Үдэш зул өргөх цагт Майдарын тангарагийн тарни, ерөөл сэлийг тасралтгүй уншиж айлддаг. Түүнээс нийт ба нийт бусын уншлага машид олон буй гэжээ.

“Орон ажрахын өмнөхөн хөвгүүд шавь нараас бодитой хувилгаан дүр хаана залрахыг айлтгасанд “би алс холд машид ариун гэлэн болж төрөх тул та бүхэн эрэхэд нэн бэрх тул орхивоос сайн” хэмээн айлдсан гээд дараагийн бүлэгт нас барахын сүүлийн хэд хоногт шавь нараас нь ямар аврал гүрэм уншив, ямар зан үйл үйлдэв гэдгийг дэлгэрэнгүй биш боловч маш тодорхой, өөрөө дэргэд нь байсан маягтай нарийн тоочиж бичсэн байна. Шарилыг чандарлах үед ийм тийм үзэгдэл гарав гээд, суварга байгуулсныг хүртэл дурджээ. Тухайлбал, 7-р бүлэгт цагаагчин тахиа жил нас барснаас нь хойш суварга шүтээн байгуулсан, дүрийг нь бүтээсэн зэргийг буюу 1920-21 оны хар нохой жилээс харагчин гахай жил хүртэлх үйл явдлыг, суварга дотроо юу юу шүншиглэсэн, ямар ном барлаж хийсэн, ямар бурхан залсныг тодорхой бичсэн байна.

Төгсгөлийн шүлэгтээ:

སྒྲོལ་གཉིས་ཐུན་ལྷུག་སེལ་ལ་དབང་འབྱོར་ཟག་མེད་ཡེ་ཤེས་ཆ་ཀུན་ཇོགས།།ཚོགས་གཉིས་རྒྱ་མཚོ་སྒྲོལ་ལ་དབང་འབྱོར་གསུང་དབྱངས་འོད་དཀར་ཕྱོགས་བཅུར་འཛིན།།དོན་གཉིས་མཐའ་དག་རྒྱས་ལ་དབང་འབྱོར་མཚན་དཔེ་ར་དགས་མཚན་མས་མཇོས།།རྒྱ་གཉིས་ཡོན་ཏན་ཀུན་ལ་དབང་འབྱོར་སྣ་བའི་རྩ་བར་སྣར་ཡང་འདུད།།མགོན་འདིའི་ལུང་དང་རྗོགས་པའི་ཡོན་ཏན་རབ་ཏུ་བརྗོད་པའི་ཇོད་ཁྱེད་དག།དད་ཕྱན་ཐོ་ཡོངས་ཀྱི་སྲིང་གི་གཏུང་བ་མ་ལུས་སེལ་བའི་སྨན།།གང་ཞིད་བསྟེས་པ་དོན་དང་ལྡན་ཏེ་དམ་པའི་ཡོན་ཏན་རྣེས་བྱན་དང་།།ཐོས་བསམ་སྒོམ་ལ་རིམ་གྱིས་འཇུག་པའི་ཚུལ་ལུགས་གསལ་བར་ཁྱེད་པཱན་ཡིན།། [Принлайжамц 2001: 27] мөн Ишжамц гэдэг багшийнхаа нэрийг оруулаад эхний 4 мөр харьцангуй урт 15 үетэйгээр, дараагийн 4 мөрдөө номынхоо нэрийг оруулж бичжээ. Ингэж номын нэр оруулж төгсгөлийн шүлэг бичсэн нь бусад номд тэгтэл харагддаггүй, зохиогчийн зохист аялгууны авьяас эрдэм харагдаж байгаа онцлог юм.

Үүнийхээ дараагийн 4 мөрд намтар цадигийг үзсэний ач тус, даган баясахын ач тусыг гаргаад, эцэст нь бусад зохиолын адил сонссон нь бага, эндүү ташаагаа хүлцсэн шүлгийг дагалдуулж, намтрыг бичиж туурвисны буяны зориулга ерөөлийн шүлгийг нэлээн хэдэн бадгаар гаргаад, эцэст бар хэвлэлийн товч 4 шад ерөөлөөр энэ зохиол төгсөж байна.

ДҮГНЭЛТ

Бид энэ намтрын зохиогчийн тухай нарийн мэдээлэл олж чадсангүй. Монгол, төвөд үндэстэн алин болохыг нарийвчлан тодруулах шаардлагатай. Гэвч намтрын төгсгөлийн үгэнд Диза хийдэд бичсэн гэж буй. Энэ Диза хийдийн нэр нь Ганданшаддүвдаржайлин. Хөх нуурын өмнө талд байдаг одоогийн Шин хай шяньд харьяалагдана. Тэгэхээр Хөхнуур орчмын төвөд, монгол үндэстний хүн байж магад гэсэн урьдчилсан таамаг дэвшүүлж байна.

Намтрын агуулгаас харахад зохиогч нь Ишжамц ламын амьдралын сүүл үеэс хамт байсан, түүнтэй нас ойролцоо, нэгэн үеийн хүн ажээ. Иймд 20-р зууны эхэн үед зохиол бүтээлээ туурвиж байсан, зохист аялгуу, холбон найруулах арга ухаанд цагаарсан эрдэмтэн байжээ гэж үзэж байна. Ишжамц лам түүнд өөрийнхөө багшийн намтрыг дэлгэрүүлэн зохио гэж айлдаж байснаас үзвэл ном зохиол туурвин зохиох билиг авьяастай, нэгээр тогтохгүй бүтээлтэй хүн бололтой.

Принлайжамцын бичсэн энэхүү намтарт Хорчин нутгийн ноёдын залгамж, алив орон хийдийн цанид чойрын ном хэлэлцэх ёсны нарийн ялгаа журам, хэрхэн явагдаж байсан, нийгмийн байдал зэргийг тодорхой гаргасан бөгөөд түүх догжод гэдэг утгаараа ч түүхийг тодорхой өгүүлсэн зохиол боловч тахил, төгсгөл, завсрын шүлэг тэргүүтнээр уран яруу чимэглэн бичсэн, үгийн сонголт уран яруу, хүндэтгэл бишрэлийн өнгө аяс түлхүү зэргээс энэ намтар зохиол нь 20-р зуунд бичигдсэн түүх, уран зохиолын хосолмол дурсгал гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

[Ишжамц] rje btsun hor chen pa ye shes rgya mtsho'i dogs dpyod phyogs bsdus bzhugs so// Дээд богд Хорчин Ишжамцын зохиолын эмхэтгэл. Дээд, доод дэвтэр. Хонконгийн Тиан ма хэвлэлийн хороо, 2001

[Принлайжамц] gzhung brgya smra ba'i dbang po bka' drin mnyam med rje btsun ye shes rgya mtsho dpal bzang po'i rtogs brjod pa dad ldan snying gi gdung sel shes bya ba bzhugs so// rje btsun hor chen pa ye shes rgya mtsho'i dogs dpyod phyogs bsdus bzhugs so// (stod cha.) Хонконгийн Тиан ма хэвлэлийн хороо, 2001. т.1-28

[Гүнбум данрав] gser tog blo bzang tshul khrims rgya mtshos brtsams/ sku ‘bum byams pa gling gi gdan rabs don ldan tshangs pa’i dbyangs snyan// Хөхнуурын үндэстний хэвлэлийн хороо, 1982

[Сүнбум гарчиг] zhwa ser bstan pa’i sgron me rje tsong kha pa chen pos gtsos skyes chen dam pa rim byung gi gsung ‘bum dkar chag phyogs gcig tu bsgrigs pa’i dri med zla shel gtsang ma’i me long zhes bya ba bzhugs so// rtsom sgrig ‘gan khur ba/ lhag pa tshe ring/ Хөхнуурын үндэстний хэвлэлийн хороо, 1990.

Гомбожав 2005: *Гомбожав С.* Монголчуудын түвд хэлээр зохиосон зохиолын зүйл. (Монгол бичгээс хөрв: С.Даваабаяр). УБ.: “Соёмбо принтинг”ХХК, 2005

Ёндон 1976: *Ёндон Д.* Монголчуудын төвөд хэлээр бичсэн уран зохиолын тойм//Монголын уран зохиолын тойм (XVII-XVIII зуун). Хоёрдугаар дэвтэр. (Ред: Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд).УБ.,1976. т.579-596.